



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 167

Баян-Овоо

**Засаг даргын нөөцөөс зардал гаргах
тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1. Бдэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдах “Дадал Намрын баяр-2024” үзэсгэлэн худалдаа арга хэмжээний шагналын зардал гаргасугай.

2. Шагналын сан болох 1.935.000 (Нэг сая есөн зуун гучин таван мянган) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД

010000367